



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорнод аймгийн Гурванзагал сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/148 /СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Чойбалсан хот

2020 он

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас: 7058-4204 Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn

Аудитор: Ө.Сийлэгмаа

Утас: 7000-3775

Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НӨАТТХ	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль
НЭМ	Нийгмийн эрүүл мэндийн төв

ТБОНӨБҮХАТХ Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хуувь



Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
Менежментийн захидал	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	12
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	16
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	17
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	17



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.02.27 № 251

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гурванзагал сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Гурванзагал сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Гурванзагал сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110520284



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалтын дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.1. Оршил

Дорнод аймгийн Гурван загал сумын сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Л.Зулцэцэг Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Гурван загал сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Гурванзагал сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дүгээр сарын 18-наас 2020 оны 02 дугаар сарын 24-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 ны 02 дугаар сарын 27 -ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорнод аймгийн Төрийн аудитын газрын захиалгаар “Хаан консалтинг аудит” ХХК-ийн аудитор Ө.Сийлэгмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Дорнод аймгийн Гурванзагал сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорнод аймгийн Гурван загал сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Сумын иргэд харъяа байгууллагуудад эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй үзүүлнэ” гэж тодорхойлсон байна.

Дорнод аймгийн Гурван загал сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Зорилт 1: Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн, салбар дундын хамтын ажиллагаа, олон нийтийн оролцоог сайжруулна.

Зорилт 2: Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлнэ.

Зорилт 3: Хүний нөөцийн бодлогыг эрэлтэд нийцүүлэн тогтвортой хөгжүүлж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй харилцаа, хандлагыг төлөвшүүлэх үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангана.

Зорилт 4: Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн ил тод байдлыг хангаж, орон нутгийн хөрөнгө оруулалтыг тогтвортой нэмэгдүүлнэ.

Зорилт 5: Эрүүл мэндийн технологийн дэвшлийг эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэвтрүүлэн байгууллагын хөгжил, ээлтэй байдлыг бүрдүүлнэ.

Зорилт 6: Эм зүйн тусламж үйлчилгээний хүртээмжтэй тогтвортой байдлыг ханган, зайлшгүй шаардлагатай, баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй хангана.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Гурванзагал сумын Эрүүл мэндийн төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Гурванзагал сумын Эрүүл мэндийн төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Ахрloger программ хангамж ашигладаг байна.

Гурванзагал сумын Эрүүл мэндийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд үр нөлөөтэй гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Гурванзагал сумын Эрүүл мэндийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 41 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 20019 оны жилийн эцсийн тайланг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 298,154.8 мянган төгрөгөөс тооцон 5,963.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 5,963.1 мянган төгрөгөөр тооцсон болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Гурванзагал сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14,203.9 мянган төгрөгөөр буюу 3.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	00.00	00.00	-
Авлага	00.00	00.00	-
Урьдчилгаа	00.00	00.00	-
Бараа материал	19,869.7	29,778.8	9,876.3
Үндсэн хөрөнгө	492,027.4	526,312.8	34,285.4
Хуримтлагдсан элэгдэл	-61,287,6	91,667,7	-30,380,1
Нийт хөрөнгө	450,642,3	464,423,8	14,203,2
Өр төлбөр	00.00	00.00	00.00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	450,642,3	464,423,8	14,203,2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	450,642,3	464,423,8	14,203,2

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь 9,876.3 мянган төгрөгийн үнэ төлбөргүй эм, эмнэлгийн хэрэгсэл орлого болгосноос шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 6,090.0 мянган төгрөгийн, сумын орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр 9,500.0 мянган төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмж, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр 14,400.4 мянган төгрөгийн халаалтын тогоо, төсвийн урсгал зардлаас 4295,0 мянган төгрөгийг тавилга, тоног төхөөрөмж худалдан авсантай холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 14,203,2 мянган төгрөгөөр өссөн нь дээрх бараа материалын болон үндсэн хөрөнгийн өсөлтөөс шалтгаалжээ.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан үндсэн үйл ажиллагаанд 284.301.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас тусгай зориулалтын шилжүүлгээр 256,434.1 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын санхүүжилт 14,298.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 13,569.4 мянган төгрөгийн зардал тус тус төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 272,029.3 мянган төгрөг буюу 95.6 хувьтай байгаа нь эрүүл мэндийн даатгалын 12,272.2 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу авсантай холбоотой.

Нэмэлт төсөв: Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас Ахмадын болон хүүхдийн сувиллын зардалд 800.0 мянган төгрөг, ХӨСҮТ-ээс сүрьеэгийн сорьц тээвэрлэх замын зардалд 184.8 мянган төгрөгийн санхүүжилтээр нэмэлт дансны орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс: тээвэр шатахууны зардалд 184.8 мянган төгрөг, сувиллын эм, хоолны зардалд 800.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 41 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 41 эрсдэл тодорхойлж нийт 41 горим сорил хэрэгжүүлжээ.

Аудитаар нийт 52,336.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 13,224.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 38,912.1 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 200,0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Аудитаар дараах мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 38,912,1 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал

Тайлант хугацаанд нийт 74,840,5 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан боловч эдгээрээс 40,868.6 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ нь е-баримттай, 33,971.9 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ е-баримтгүй байгаа нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 3.1.3 дахь заалтад “анхан шатны баримт гэж, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 13.4 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь заалтад “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага өгөв.

1. Зардлын данстай холбоотой асуудал

Ерөнхий журналын бичилтүүдийг бүхэлд нь шалгаж үзсэнээс алдаатай байх магадлалтай 47 ажил гүйлгээний журналын бичилтыг шалгахад 32 гүйлгээ буюу 4,940.3 мянган төгрөгийн гүйлгээг тооцооны дансаар дамжуулахгүй шууд зардлын дансанд бичсэн байна. Энэ нь Үнэлгээ ба хуваарилалт, гэсэн батламж мэдэгдэлтэй зөрчилдөж байгаа бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3, 13.4, 13.5, Төсвийн тухай хуулийн 41.2.3 тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

1. Бараа материалыг орлого авахгүй зардалд бичдэг зөрчил 2 жил дараалан албан шаардлага өгч байгаа тул үүнийг дараагийн аудитаар анхаарах.

2. Төсөл хөтөлбөрүүдээс үнэ төлбөргүй ирдэг эм, вакцин, оношлуур гэх мэт эм, эмнэлэгийн хэрэгслийг санхүүгийн тайланд бүртгэхгүй байх асуудал

2.13. Шилэн дансны мэдээлэл

Гурванзагал сумын Эрүүл мэндийн төв нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 148 мэдээллээс 110 мэдээлэлийг хугацаандаа, 41 мэдээллийг хугацаа хоцроож 74.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 4,842.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлснээс албан шаардлагыг биелүүлээгүй буюу зөрчлийг дахин давтан гаргасан байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Гурванзагал сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Гурванзагал сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Биет бус хөрөнгөнд бүртгэлтэй элэгдлийн хугацаа дууссан, ашиглагдахгүй байгаа 200.0 мянган төгрөгийн өртөг бүхий 1 программ хангамжийг данс бүртгэлээс хасаагүй байна.

1.2. Эрсдэл:

Дүрэм, журам хэрэгжихгүй бөгөөд, хөрөнгө нь үр өгөөжөө өгөхгүй болсон байна.

1.3. Өгсөн зөвлөмж:

Журмын дагуу данс бүртгэлээс хасах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг дагаж мөрдөж ажиллана.

2. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Санхүүгийн программ хангамжын үйлдлийг хялбарчлах зориулалт бүхий “yes ” гэдэг команд нь бүртгэлийг буруу хийхэд хүргэж байна.

2.2 Эрсдэл:

Санхүүгийн программ хангамжыг Сангийн яамнаас тогтоосон шаардлагыг хангаагүй байх, санхүүгийн тайлан алдаатай байх.

2.3 Өгсөн зөвлөмж:

Тухайн байгууллагад ашиглагдаж байгаа нягтлан бодох бүртгэлийн програм хангамж Сангийн яамнаас тогтоосон шаардлагад нийцүүлэн стандартын дагуу боловсронгуй болгох.

2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлнэ.

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэ	Эцсийн үлдэгдэ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	19,902,517.2	29,778,776.2
35	БАРАА МАТЕРИАЛ	19,869,725.9	29,778,776.2
351	Түүхий эд материал	2,110,243.4	4,322,143.7
35110	Тусгай зориулалттай материал	965,000.0	2,025,000.0
35130	Эм боох материал	1,145,243.4	2,297,143.7
354	Хангамжийн материал	11,035,295.0	15,794,445.0
35410	Бичиг хэргийн материал	63,000.0	63,000.0
35420	Аж ахуйн материал	8,737,597.5	10,137,597.5
35440	Түлш, шатах тослох материал	474,670.0	3,246,000.0
35460	Хүнсний материал	1,054,027.5	1,041,847.5
35470	Бусад хангамжийн материал	706,000.0	1,306,000.0
35600	Мал амьтад	6,724,187.5	9,662,187.5
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	430,739,749.2	434,645,122.7
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	430,739,749.2	434,645,122.7
392	Биет хөрөнгө	417,682,949.2	421,588,322.7
39201	Барилга, байгууламж, орон сууц	327,415,422.3	327,415,422.3
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(6,716,746.0)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	32,556,946.0	32,556,946.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	(8,845,657.2)	(14,715,085.5)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	60,538,146.4	61,063,146.4
39206	Хуримтлагдсан элэгдэл	(33,701,886.4)	(42,534,528.4)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,383,950.0	11,673,950.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	(3,702,465.5)	(5,648,083.5)
39209	Зам, гүүрийн байгууламж	24,625,723.0	24,625,723.0
39210	Хуримтлагдсан элэгдэл	(9,439,860.5)	(14,365,005.2)
39214	Бусад үндсэн хөрөнгө	22,250,425.0	55,720,832.0
39215	Хуримтлагдсан элэгдэл	(5,397,794.0)	(7,488,248.5)
393	Биет бус хөрөнгө	13,056,800.0	13,056,800.0
39301	Програм хангамж	200,000.0	200,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	(200,000.0)	(200,000.0)
39303	Бусад биет бус хөрөнгө	13,056,800.0	13,056,800.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	450,642,266.4	464,423,898.9
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	450,220,652.4	464,423,898.9
51	Засгийн газрын хувь оролцоо	450,220,652.4	464,423,898.9
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	225,484,258.4	225,484,258.4
512	Хуримтлагдсан үр дүн	19,617,034.8	33,820,281.3
51210	Өмнөх үеийн үр дүн	18,889,572.8	19,617,034.8
51220	Тайлант үеийн үр дүн	727,462.0	14,203,246.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	205,119,359.2	205,119,359.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	450,642,266.4	464,423,898.9

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	281,459,795.0	312,358,090.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	39,038,395.0	311,373,290.1
120	Нийтлэг татварын бус орлого	16,708,390.0	39,328,790.1
120,004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16,708,390.0	2,989,000.0
1,200,045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	16,708,390.0	2,989,000.0
122	Тусламжийн орлого	22,330,005.0	15,610,400.0
122,001	Хандив тусламж /дотоод/	22,330,005.0	15,610,400.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	256,434,100.0
123,001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	-	256,434,100.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	242,421,400.0	984,800.0
1,311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,581,000.0	984,800.0
131,104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,581,000.0	984,800.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	280,732,333.0	298,154,843.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	280,732,333.0	298,154,843.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	280,703,503.0	298,154,843.6
2,101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	142,435,322.7	159,003,910.4
210,101	Үндсэн цалин	131,242,022.7	132,881,667.5
210,102	Нэмэгдэл	-	18,005,892.2
210,104	Урамшуулал	11,193,300.0	8,116,350.7
2,102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,524,800.0	21,462,491.3
210,201	Тэтгэврийн даатгал	12,004,800.0	14,604,991.3
210,202	Тэтгэмжийн даатгал	1,430,400.0	1,714,400.0
210,203	ҮОМШӨ-ний даатгал	1,039,200.0	1,371,500.0
210,204	Ажилгүйдлийн даатгал	277,200.0	628,600.0
210,205	Эрүүл мэндийн даатгал	2,773,200.0	3,143,000.0
2,103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,896,030.0	12,592,396.6
210,301	Гэрэл, цахилгаан	2,306,267.0	2,502,375.0
210,302	Түлш, халаалт	7,410,788.0	9,890,021.6
210,303	Цэвэр, бохир ус	178,975.0	200,000.0
2,104	Хангамж, бараа материалын зардал	16,925,810.0	18,313,080.0
210,401	Бичиг хэрэг	726,390.0	1,881,880.0
210,402	Тээвэр, шатахуун	13,817,400.0	13,800,700.0
210,403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	990,000.0	1,415,000.0
210,405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	645,400.0	730,000.0
210,406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	746,620.0	485,500.0
2,105	Нормативт зардал	15,393,898.0	28,296,762.8
210,501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,418,533.0	23,295,132.8
210,502	Хоол, хүнс	4,782,365.0	5,001,630.0
2,106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,090,000.0	2,724,500.0
210,601	Багаж, техник, хэрэгсэл	660,000.0	(2,301,000.0)
210,604	Урсгал засвар	2,430,000.0	5,025,500.0
2,107	Томилолт, зочны зардал	841,500.0	1,150,000.0
210,702	Дотоод албан томилолт	841,500.0	1,150,000.0



Дорнод аймгийн Гурванзагал сумын эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2,108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,383,670.0	17,240,519.0
210,801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,120,000.0	17,055,679.0
210,802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	144,000.0	93,000.0
210,804	Тээврийн хэрэгслийн татвар	63,500.0	26,000.0
210,805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	51,170.0	60,840.0
210,807	Газрын төлбөр	5,000.0	5,000.0
2,109	Бараа үйлчилгээний бусад зардал	57,212,472.3	37,371,183.5
210,901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,753,505.0	6,991,150.0
210,903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	23,458,967.3	30,380,033.5
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	727,462.0	14,203,246.5
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	727,462.0	14,203,246.5

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	264,751,405.0	273,029,300.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	22,330,005.0	272,044,500.0
122	Тусламжийн орлого	22,330,005.0	15,610,400.0
122001	Хандив тусламж /дотоод/	22,330,005.0	15,610,400.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	242,421,400.0	984,800.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,581,000.0	984,800.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,581,000.0	984,800.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	235,840,400.0	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	235,840,400.0	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	264,751,405.0	273,029,297.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	264,751,405.0	273,029,297.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	264,722,575.0	273,029,297.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	142,046,500.0	159,425,524.4
210101	Үндсэн цалин	130,853,200.0	132,881,667.5
210104	Урамшуулал	11,193,300.0	8,116,350.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,524,800.0	21,429,700.0
210201	Тэтгэврийн даатгал	12,004,800.0	14,572,200.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,430,400.0	1,714,400.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,039,200.0	1,371,500.0
210204	Ажилгүйдлийн даатгал	277,200.0	628,600.0
210205	Эрүүл мэндийн даатгал	2,773,200.0	3,143,000.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,145,800.0	13,539,873.6
210301	Гэрэл, цахилгаан	2,306,267.0	2,502,375.0
210302	Түлш, халаалт	7,660,558.0	10,837,498.6
210303	Цэвэр, бохир ус	178,975.0	200,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	16,985,800.0	20,227,180.0
210401	Бичиг хэрэг	697,000.0	1,580,380.0
210402	Тээвэр, шатахуун	14,024,900.0	15,621,800.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	990,000.0	1,415,000.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,	645,400.0	730,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	628,500.0	880,000.0
2105	Нормативт зардал	20,214,500.0	26,537,500.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14,000,000.0	17,747,000.0
210502	Хоол, хүнс	4,781,500.0	6,790,500.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,433,000.0	2,000,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,826,500.0	7,394,000.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,536,500.0	1,994,000.0
210604	Урсгал засвар	4,290,000.0	5,400,000.0
2107	Томиллолт, зочны зардал	841,500.0	1,150,000.0
210702	Дотоод албан томилолт	841,500.0	1,150,000.0

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,383,670.0	17,240,519.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,120,000.0	17,055,679.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	144,000.0	93,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	63,500.0	26,000.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	51,170.0	60,840.0
210807	Газрын төлбөр	5,000.0	5,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,753,505.0	6,085,000.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,753,505.0	6,085,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,830.0	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	28,830.0	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,830.0	-

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капигал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	225,484,258.42	205,119,359.17	19,617,034.81	450,220,652.40
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	225,484,258.42	205,119,359.17	19,617,034.81	450,220,652.40
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
Тайлант үеийн үр дүн				0.00
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	225,484,258.42	205,119,359.17	19,617,034.81	450,220,652.40
2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	225,484,258.42	205,119,359.17	19,617,034.81	450,220,652.40
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	225,484,258.42	205,119,359.17	19,617,034.81	450,220,652.40
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	14,203,246.50	14,203,246.50
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	225,484,258.42	205,119,359.17	33,820,281.31	464,423,898.90

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	284,301,500.0	272,044,500.0
УРСГАЛ ЗАРДАЛ	284,301,500.0	272,044,500.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	284,301,500.0	272,044,500.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	171,437,400.0	159,425,524.4
Үндсэн цалин	133,480,600.0	132,881,667.5
Нэмэгдэл	20,832,500.0	18,427,506.2
Урамшуулал	17,124,300.0	8,116,350.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,429,700.0	21,429,700.0
Тэтэврийн даатгал	14,572,200.0	14,572,200.0
Тэтгэмжийн даатгал	1,714,400.0	1,714,400.0
ҮОМШӨ-ний даатгал	1,371,500.0	1,371,500.0
Ажилгүйдлийн даатгал	342,900.0	628,600.0
Эрүүл мэндийн даатгал	3,428,700.0	3,143,000.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,569,400.0	13,539,876.6
Гэрэл, цахилгаан	2,500,000.0	2,502,375.0
Түлш, халаалт	10,869,400.0	10,837,501.6
Цэвэр, бохир ус	200,000.0	200,000.0
Хангамж, бараа материалын зардал	20,012,000.0	20,042,380.0
Бичиг хэрэг	2,050,000.0	1,580,380.0
Тээвэр, шатахуун	14,937,000.0	15,437,000.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,415,000.0	1,415,000.0
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	730,000.0	730,000.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	880,000.0	880,000.0
Нормативт зардал	25,738,500.0	25,737,500.0
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17,747,000.0	17,747,000.0
Хоол, хүнс	5,991,500.0	5,990,500.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000.0	2,000,000.0
Эд хогшил, урсгал засварын зардал	7,400,000.0	7,394,000.0
Багаж, техник, хэрэгсэл	2,000,000.0	1,994,000.0
Урсгал засвар	5,400,000.0	5,400,000.0
Томилолт, зочны зардал	1,265,000.0	1,150,000.0
Дотоод албан томилолт	1,265,000.0	1,150,000.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хура	17,364,500.0	17,240,519.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээ	17,056,000.0	17,055,679.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.0	93,000.0
Тээврийн хэрэгслийн татвар	63,500.0	26,000.0
Тээврийн хэрэгслийн оношлогоо	80,000.0	60,840.0
Газрын төлбөр	5,000.0	5,000.0
Бараа үйлчилгээний бусад зардал	6,085,000.0	6,085,000.0
Бараа үйлчилгээний бусад зардал	6,085,000.0	6,085,000.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	284,301,500.0	272,044,500.0